# ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2021.12.20 Багахангай дүүрэг

| № | Агуулга | Нийт заалтын тоо | Бүрэн хэрэгжсэн | Хэрэгжих шатандаа | хэрэгжилт хангалтгүй | Хэрэгжээгүй | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | 100 хувь (90 -100 хүртэл хувь) | 70 хувь (50-89 хүртэл хувь) | 30 хувь (10-49 хүртэл хувь); | 0 хувь (0-9 хүртэл хувь | Үнэлгээ /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 14 | 13 | - | 1 | - | - | 13 | - | 1 | - | 95% |
| 2 | Улсын Их Хурлын тогтоол | 1 | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | 100% |
| 3 | Ерөнхийлөгчийн зарлиг | 7 | 7 | - | - | - | - | 7 | - | - | - | 100% |
| **Нийт** | | **22** | **21** | **-** | **1** | **-** | **-** | **21** | **-** | **1** | | **98.3%** |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭРДЭНЭТУЯА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН

Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлт
/жилийн эцсийн байдлаар/

2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

| № | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын хууль | | | | | |
| 1. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/<br>2016-12-22<br>Дугаар 2017.02.01 | 18.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу дэд хөтөлбөр боловсруулж батлах хууль эрх зүйн үндэслэлгүй болсон. Иймд “Эрүүл орчин–Иргэдийн сайн сайхан” III арга хэмжээний төлөвлөгөөг 4 бүлэг 20 заалттайгаар боловсруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/28 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.<br>ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, Хороодын ажлын албанаас хамтран 2021 оны 03 сарын 30, 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Алтгана, Үнэгтэй, Бор үзүүр, Цайдам, Замчин Нуурын гэр хорооллын орчимд хяналт шалгалт зохион байгуулж, байнга архи согтууруулах ундаа хэрэглэдэг, архидалт зохион байгуулдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 16 айл өрхөөр орж нөхцөл байдалтай танилцав. Шалгалтын явцад архи согтууруулах ундаа хэрэглэсэн 1 иргэнд анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, хүсэлт гаргасан 2 иргэний саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлав.<br>Гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх, илрүүлэх зорилго бүхий “Хөршийн холбоо” төслийг боловсруулах ажлын хэсэг 2 удаагийн хэлэлцүүлэг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулан, санал авч төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийг “Хэрсүү гурвалжин” төсөлтэй уялдуулан хэрэгжүүлж, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа ус түгээх газруудын түгээгч, хүнсний дэлгүүрийн худалдагчдын гурвалжинг үүсгэн мэдээллээр хангаж ажиллалаа. Хүүхдийн эрхийн зөрчил болон гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хөршүүд мэдсэн даруйдаа мэдээлдэг тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.<br>Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч 7 настай эмэгтэй, 14 настай эмэгтэй 2 хүүхдэд хууль тогтоомжид заасны дагуу хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэн сурч боловсрох, хөгжих эрхийг хангаж давтлага сургалтад хамруулан ажиллаж байна. | | |
| 2. | | 18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Орон нутгийн төсвөөс 2021 онд ГБХЗХХ-ийн үйл ажиллагааны зардалд 282.0 сая төгрөг шийдвэрлэв. Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 48.0 сая төгрөг олгосон байна. | 100% | |
| 3. | | 18.1.3.Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй | ГБХЗХХ түр хамгаалах байрыг 6 ортой 1 өрөөг тохижуулан эрсдэл өндөр үйлчлүүлэгчийг хүлээн авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй, хараа хяналт сул 1 эрэгтэй, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй, гэмт хэргийн хохирогч 2 эмэгтэй хүүхдийн аюулгүй байдлыг хангахаар түр хамгаалах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүллээ. Үүнээс эрсдэл өндөр 2 эмэгтэй хүүхдийг ХТУ-108 төв болон | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | СБД-ийн ГБХЗХХ-ийн нэг цэгийн үйлчилгээний төвд түр шилжүүлэн үйлчилгээ үзүүлж эрсдэл буурсан тул ар гэрт нь эргэн нэгтгэж үйлчилгээг үргэлжлүүлэн хяналтад авч ажиллаж байна. | | |
| 4. | | 19.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийллийн сөрөг үр дагаврын талаарх ойлголт өгөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 15 шторк, 48 постерыг орон нутгийн 7 групп, facebook цахим орчинд нийтэлж олон нийтэд түгээлээ.<br><br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрөөр жендэрт суурилсан хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр 2 удаагийн нөлөөллийн ажлыг “Яг одоо хүчирхийллийг таслан зогсооё” уриан дор иргэд олон нийтэд “Багахангай хэвлэл мэдээлэл” цахим хуудас болон дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn вэб сайтаар тус тус хүргэв. Гэр бүлийн харилцаа болон хүчирхийлэлтэй харилцаанаас үүдэх сөрөг үр дагаврын чиглэлээр давхардсан тоогоор 32 иргэнд биечлэн, 56 иргэнд цахимаар зөвлөгөө мэдээлэл өглөө.<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 2 эрэгтэй, 8 эмэгтэйд нөхцөл байдлын үнэлгээ хийж мэргэжилтэнд шилжүүлж, үйлчилгээнд хяналт тавин хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн. Гэр бүлийн хүчирхийллийн 1 тохиолдлыг 2 дугаар хорооны хамтарсан багт шилжүүлэн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.<br>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 06 дугаар тогтоол, Засаг даргын 2017 оны А/137 дугаар захирамжаар сар бүрийн сүүлийн долоо хоногийн “Бямба” гарагийг “Гэр бүлийн өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэр, “Хүүхдэд ээлтэй Багахангай“ дэд хөтөлбөрийн хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс сар бүр гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган байгууллага бүр гэр бүл, хүүхдэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэвшээд байна. Үүнд: Сургалт нөлөөллийн ажлыг цахимаар 14 удаа, "Миний гэр бүл" сэдэвт гар зургийн уралдаан, "Хүүхдийн эрхийг хамгаалах нь" сэдэвт эссэ бичлэг, "Сэтгэлийн үг" захидал бичих, "Хүүхдийн дууг хэн сайн дуулах вэ" гэр бүлийн дууны тэмцээн, "Ардын бүжгийг хөгжүүлэх нь" гэр бүлийн бүжгийн тэмцээн гэх мэт 12 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийт 68 иргэн хамрагдсан байна.<br>НГБХЗХГ-аас бэлтгэн хүргэж буй "Гэр бүлийн боловсрол олгох" 8 цуврал хичээлийг аж ахуйн нэгж, байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан албан хаагчид, тэдгээрийн гэр бүлд хүргэв. Дээрх видео бичлэг, цуврал хичээлийг 4 facebook группээр дамжуулан хүргэж, 3400 орчим хүний хандалт авсан байна.<br>"Гэр бүлийн өдөр"-өөр 19 байгууллагын 362 албан хаагчдад гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт зохион байгуулав | | |
| 5. | | 19.1.2.Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 3 сургалт, 3 хэлэлцүүлгийг цахимаар, 1 сургалт танхимаар зохион байгуулсан ба сургалтад давхардсан тоогоор 75 хүн хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ. Хамтарсан багийн гишүүдэд кейс үйлчилгээ үзүүлэх, чиглэлээр цахим зөвлөгөө 6 удаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт бичих чиглэлээр ажлын байран дээр 5 удаа арга зүйн, зөвлөгөө өгч ажиллалаа. | 100% | |
| 6. | | 19.1.3.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй | Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулаагүй ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр ГБХЗХХ түр хамгаалах байрыг 6 ортой 1 өрөөг тохижуулан эрсдэл өндөр үйлчлүүлэгчийг хүлээн авч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах талаарх хүсэлтийг дүүргийн ГХУСАЗСЗ-д хүргүүлэн шийдвэрлэх шатандаа байна. | 30% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | |
| 7. | | 19.1.4.Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулах 1 заалтыг тусган дүүргийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутгийн төсвөөс ГБХЗХХ-ийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэн ажиллаж байна. | 100% | |
| 8. | | 19.1.5.Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Орон нутгийн төсвөөс 2021 онд ГБХЗХХ-ийн үйл ажиллагааны зардалд 282.0 сая төгрөг шийдвэрлэв. Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 48.0 сая төгрөг олгосон байна. | 100% | |
| 9. | | 19.1.6.Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьялах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг | 2021 оны жилийн эцсийн байдлаар хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй, хараа хяналт сул 1 эрэгтэй, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэй, гэмт хэргийн хохирогч 2 эмэгтэй хүүхдийн аюулгүй байдлыг хангахаар түр хамгаалах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүллээ. Нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах талаарх хүсэлтийг дүүргийн ГХУСАЗСЗ-д хүргүүлэн шийдвэрлэх шатанд явж байна. Тус дүүргийн нутаг дэвсгэрт төрийн бус байгууллагуудтай хамтран гэрч, хохирогчийг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлнэ: | хамгаалж, туслалцаа үзүүлдэг иргэд, мэргэжлийн бүлэг, ажилтнууд байхгүй бөгөөд цаашид энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байууллагатай хамтран ажиллах талаар судалж байна. 2021 онд нийтдээ 10 урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүүлэн ажилласан. Цаашид хамгаалалтад авагдсан иргэдийг ажлын байраар хангах, мэргэжилийн сургалтанд хамруулах арга хэмжээг холбогдох газруудтай хамтран хэрэгжүүлж ажиллахаар харилцан ярилцаж мэдээ мэдээлэл солилцон ажиллаж байна. Энэ онд Дүүргийн гэр бүл хүүхэп залуучуудын хэлтэстэй хамтран 4 дуудлага мэдээлэлд хамтарсан багийн үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээг гаргаж ажилласан. | | |
| 10. | | 19.1.7.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Дүүргийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байхгүй бөгөөд дүүргийн Цагдаагийн хэлтэс, Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс гэр бүлийн хүчирхийллийн дуудлага бүр дээр хамтран ажиллаж байна. Цагдаагийн хэлтэс, иргэн Тунгалагийн хариуцсан “Бид хамтдаа” ТББ хамтран архинаас гаргах зорилгоор архины хамааралтай 5 иргэнийг сайн дурын үндсэн дээр хорт зуршлаас татгалзах сургалтад хамруулсан. Мөн “Эр зоригийн хүч” ТББ-тай ГБХЗХХ хамтран архины хамааралтай иргэдийг архинаас гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан. | 100% | |
| 11. | | 19.1.8.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулж, Цагдаагийн хэлтэстэй хамтран дүүргийн хэмжээнд 25 урамшуулалт эргүүл, хороод тус бүрд 1 хүүхэд хамгаалагч ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд дүүргийн урамшуулалт эргүүлийн урамшууллыг ГХУСАЗСЗ-өөс, хүүхэд хамгаалагчийн урамшууллыг ХХҮХ-ээс санхүүжилтийг шийдвэрлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | сэргийлэх ажилд иргэдийн оролцоог хангах ажлын хүрээнд Хөршийн хяналт арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Хөршийн хяналт арга хэмжээг "Хэрсүү гурвалжин" төсөлтэй уялдуулан хэрэгжүүлж дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа ус түгээх газруудын түгээгч, хүнсний дэлгүүрийн худалдагчдын гурвалжинг үүсгэн мэдээллээр хангаж ажиллаж байна. | | |
| 12. | | 25.2.Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно. | Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2021 оны Б/67 тоот тушаалаар тус дүүргийн Цагдаагийн хэлтэст хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо бий болгон, холбогдох албан тушаалтныг томилоод байна. Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2021 оны тушаалаар хэсгийн байцаагч, Мөрдөгч болон сургагч багш томилон ажиллуулаа. | 100% | |
| 13. | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | ЗДТГ Төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх ажлын хүрээнд шинээр ажилд томилогдсон 14 албан хаагчийг ажлын байран дээр нь дадлагажуулан, дээд шатны болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан 47, цаг үеийн холбогдолтой 39 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулав.<br>**Мөн төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх ажлын хүрээнд** дүүргийн төрийн байгууллагууд дээд шатны болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад албан хаагчдаа хамруулсан байна. Үүнд:<br>-ХААА: 11 сургалтад давхардсан тоогоор 16 албан хаагч,<br>-Соёлын ордон: 12 сургалтад давхардсан тоогоор 530 албан хаагч,<br>-207-р цэцэрлэг: 18 сургалтад давхардсан тоогоор 136 албан хаагч,<br>44-р цэцэрлэг: 5 сургалтад давхардсан тоогоор 44 албан хаагч,<br>-ДАА: 18 сургалтад давхардсан тоогоор 36 албан хаагч, | 100 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | -ЖДҮДТ:<br>-НДХ: 18 сургалтад давхардсан тоогоор 72 албан хаагч,<br>-ҮТП: 45 сургалтад тоогоор 50 албан хаагч,<br>-Татварын хэлтэс 13 сургалтад давхардсан тоогоор 26 албан хаагч,<br>-ОБХ: ОБЕГ, НОБГ, бусад байгууллагаас зохион байгуулсан 25 удаагийн цахим болон танхимын сургалтад офицер бүрэлдэхүүнээс давхардсан тоогоор 25, ахлагч бүрэлдэхүүн 67, нийт 92 алба хаагч,<br>-ЦХ: 120 сургалтад 2212 албан хаагч,<br>-БТСХ: 9 сургалтад 27 албан хаагч ,<br>-УБХ: 28 сургалтад 25 албан хаагч,<br>-Илч-Орд ОНӨААТҮГ: 5 сургалтад 56 албан хаагч,<br>-Багахангай тохижилт ОНӨААТҮГ: 3 сургалтад давхардсан тоогоор 55 албан хаагч ,<br>ХХҮХ: 24 сургалтад давхардсан тоогоор 29 албан хаагч,<br>ГБХЗХХ: 26 сургалтад давхардсан тоогоор 127 албан хаагч,<br>Боловмролын хэлтэс: 89 сургалтад давхардсан тоогоор 80 албан хаагч,<br>ЭМТ: 77 сургалтад давхардсан тоогоор 197 албан хаагчийг тус тус сургалтад хамруулж мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлэн ажилласан байна.<br><br>**Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд:**<br>ДАА 1 улсын байцаагчийн эрхийг 2 жилээр сунгуулсан. 1 төрийн захиргааны албан тушаалын дэд зэрэг олгож албан тушаалын үндсэн цалингийн 22 хувийн нэмэгдэл олгосон. Тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид 1.000.000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.<br>ЗДТГ:<br>➢ 8 албан хаагчид цалингийн шатлалыг | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлж;<br>➢ Ур чадварын нэмэгдлийг 3 албан хаагчид шинээр олгож;<br>➢ Цолны нэмэгдлийг 2 албан хаагчид 2 хувиар нэмэгдүүлж;<br>➢ 2 албан хаагчид онцгой нөхцөлийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 10 хувиар олгуулж;<br>➢ Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 7 албан хаагчид сарын үндсэн цалингийн 40 хувиар олгож;<br>➢ 4 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлж;<br>➢ 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 1 албан хаагчид шинээр олгуулж,<br>➢ 4 албан хаагчид нийгмийн асуудлыг нь шийдвэрлэн дэмжлэг үзүүлж,<br>➢ 20 албан хаагчид түлээ нүүрсний дэмжлэг үзүүлж,<br>➢ 1 албан хаагчид 500.000 төгрөгийн тэтгэмж олгуулж,<br>➢ Нийт албан хаагчдад гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн улирлын ажлын урамшууллыг сарын үндсэн цалингийн 36-40 хувиар олгуулж байна.<br>□ ЕБС, СӨБ-ын байгууллагуудын багш ажилчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын хүрээнд 129 айлын түрээслээд өмчлөх орон сууцанд 10 багш, ажилтныг хамруулаад байна. НИТХТ-ын 2019 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн зорилтот иргэдэд түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ийн дагуу НОСК-аас сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 90 иргэнтэй гэрээ байгуулан түлхүүрийг гардуулж өгөөд байна.<br>ЗДТГ, БТСХ, ЭМТ, ЦХ, 44-р цэцэрлэг, СО, ГБХЗХХ зэрэг байгууллагууд гэр хороололд амьдардаг албан хаагчиддаа 8.5530.000 төгрөгийн түлээ, нүүрний дэмжлэг олгосон байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Багахангай тохижилт ОНӨААТҮГ өвлийн нормын хувцасны эдэлгээ дууссан тул "Түшигт богд хан" ХКК-аас 5.593.500 төгрөгөөр нормын хувцас авч албан хаагчдыг хангаан, халуун аарц тогтмол өгч, дархлааг дэмжин ажиллаж байна.<br>НДХ: ар гэрийн гачигдлаар, эмнэлгийн оношилгоо, ковид-19 өвчнөөр өвдсөн зэрэг нийт 5 албан хаагчдад 940 000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>ЭМТ: 27 албан хаагчдад тусламж дэмжлэг үзүүлэв.<br>ҮТП: Байгууллагын 3 албан хаагчид тус бүр 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгов.<br>ХХҮХ:<br>1.Өвчний улмаас эмнэлэгт хэвтсэн 1 албан хаагчид 240,000 төгрөг, аав нь өөд болсон 1 албан хаагчид 370,000 төгрөгийн тусламж, дэмжлэг<br>2. Хэлтэст харъяалалтай 3 ахмад настанд Цагаан сар, Ахмадын баярыг тохиолдуулан 300,000 төгрөгийн гарын бэлэг,<br>3. Шинээр мэндэлсэн 3 хүүхдэд 450,000 төгрөгийн тэтгэмж,<br>4. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хэлтсийн албан хаагчдын 29 хүүхдэд 580,000 төгрөгийн бэлэг олгох ажлыг зохион байгуулсан.<br>ЦХ: 72 албан хаагчид 2 удаагийн 3,851,000 төгрөгийн хүнсний хангамж, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, аюулгүй маск, амин дэм, санитол, бээлий, хамгаалах хувцас хэрэглэлийг 27 удаа тоо ширхэгийн дагуу хуваарилж олгов. | | |
| 14. | Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01 01 | 8 1 Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно | Татварын ерөнхий хууль болон дагалдан гарсан татварын салбар хуулийн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/01 тоот малын тоо толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг тогтоосон тогтоолын дагуу дараах ажлуудыг хийж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэсэн. Татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг статистикийн тухай хуульд заасны дагуу өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэнэ гэсний дагуу дүүргийн 1, 2 дугаар хорооноос болон дүүргийн стастистикийн хэлтсээс 2020 оны тооллогод хамрагдсан 1 дүгээр хорооны 109, 2 дугаар хорооны 134 малчин болон мал бүхий иргэдийн судалгааг тус тус гаргуулан авсан. Татвар хамрагдах иргэн татвар төлөгчид сургалт сурталчилгаа хийж 88 ширхэг материалыг татвар төлөгч нарт тараалаа.<br>Хэлтсийн page хуудас болон facebook хаягаар татвар төлөгч нарт мэдээлэл хүргэн ажиллалаа. Татварын нэхэмжлэх үүссэн 36 татвар төлөгчийн 1,434.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Хуулийн дагуу 2021.12.15-ны дотор тайлан илгээх 255 иргэнээс 193 тайлан ирүүлсэн 75%-тай ажиллаж байна | | |
| Хэсгийн дундаж үнэлгээ 95% | | | | | |
| Улсын их хурлын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 15. | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.8.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн | Гэр бүлийн хүчирхийллийн сөрөг үр дагаврын талаарх ойлголт өгөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 15 шторк, 48 постерыг орон нутгийн 7 групп, facebook цахим орчинд нийтэлж олон нийтэд түгээлээ. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрөөр жендэрт суурилсан хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр 2 удаагийн нөлөөллийн ажлыг “Яг одоо хүчирхийллийг таслан зогсооё” уриан дор иргэд олон нийтэд “Багахангай хэвлэл мэдээлэл” цахим хуудас болон дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn вэб сайтаар тус тус хүргэв. Гэр бүлийн харилцаа болон хүчирхийлэлтэй харилцаанаас үүдэх сөрөг үр дагаврын чиглэлээр давхардсан тоогоор биечлэн 32 иргэн, цахимаар 56 иргэнд зөвлөгөө мэдээлэл өглөө. Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд 3 сургалт, 3 хэлэлцүүлгийг цахимаар, 1 сургалт танхимаар зохион байгуулсан ба сургалтад | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах | давхардсан тоогоор 75 хүн хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ. Хамтарсан багийн гишүүдэд кейс үйлчилгээ үзүүлэх, чиглэлээр цахим зөвлөгөө 6 удаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт бичих чиглэлээр ажлын байран дээр 5 удаа арга зүйн, зөвлөгөө өгч ажиллалаа. Тайлангийн хугацаанд Нийслэлийн ГХУСАЗСЗ, болон Хүний эрхийн үндэсний комиссоос хамтарсан багийн үйл ажиллагаанд 2 удаа шалгалт зохион байгуулав. Нийслэлийн ГБХЗХХ-ээс зохион байгуулсан Нийслэлийн 9 дүүргийн шилдэг Хамтарсан багийг шалгаруулах уралдаанд 2 дугаар хорооны хамтарсан баг амжилттай оролцож тусгай байр эзлэв. | | |
| Хэсгийн дундаж: 100% | | | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 16. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Дүүргийн хэмжээнд ЕБС, СӨБ-ын байгууллагууд гадна хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан байна. Худалдаа үйлчилгээний байгууллагуудад гадна хаягаа монгол бичгээр бичиж байршуулах чиглэл өгч ажилласнаар 3 ААНБ хаягаа шинэчлээд байна. Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол бичгээр дурсгалын зүйл бичиж өрхийн орлого олдог 1 иргэний төслийг ХХҮХ-ээс дэмжиж 5.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулаад байна. Шинэ жилийн баярыг угтан ЖДҮДТ, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нартай хамтран хүүхдийн бэлэгний уутыг даавуугаар оёж шошгыг Монгол бичгээр бичин 4500 төгрөгөөр борлуулж эхэлсэн бөгөөд дүүргийн ГБХЗХХ холбогдох байгууллагууд энэхүү үйл ажиллагаа, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарыг дэмжин худалдан авалт хийн өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 17. | | 4.Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" үндэсний хөтөлбөрийн холбогдох заалтыг хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | санаачилга гарган ажиллахыг уриалан ажиллаж байна. Дүүргийн Соёлын ордон Хангай цогцолбор сургуулийн багш нартай хамтран Монгол бичиг сурах аян өрнүүлж 2021 оны 11 дүгээр сараас эхлэн Цахимаар Монгол бичгийн хичээлийг заасан бичлэгийг дүүргийн 5 facebook пэйж хуудсаар дамжуулан иргэдэд хүргэн ажиллав. Мөн Боловсролын хэлтсээс насан туршийн боловсрол хариуцсан 1 багштай хамтран Монгол бичгийн хичээлийг заах ажлыг эхлүүлээд байна. | | |
| 18. | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23 | 1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх | Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын дагуу "Эх орныхоо 330 сум, нийслэлийн хороодоос тус бүр 1 шилдэг сурагчийг шалгаруулж, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулах Ерөнхийлөгчийн нэрэмжит "Илгээлт-2100" хөтөлбөрт 2020-2021 оны хичээлийн жилд тус дүүргийн 12 дугаар анги төгсөгчдөөс 1 дүгээр хорооноос С.Дөлгөөн, 2 дугаар хорооноос Г.Гантөмөр нар элсэлтийн ерөнхий шалгалтад Англи хэл болон Математикийн хичээлээр хамгийн өндөр оноо авсан үзүүлэлтээр шалгарлаа. Хөтөлбөрт шалгарсан сурагчид 1 жилийн хугацаанд БШУЯ-ны баталсан бэлтгэл хөтөлбөрт элсүүлэн суралцуулж, ерөнхий эрдмийн болон гадаад хэлний хичээлээр бэлтгэхээс гадна харилцааны чадвар, албан бичгийн чадвар, суралцах орны соёл, нийгмийн хариуцлага, олон нийтийн ажил зэрэгт сургаж бэлтгэх юм. Мөн Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу зарлагддаг тэтгэлгийн болзлыг хангах, сонгон шалгаруулалтад тэнцэхэд шаардлагатай мэдлэг, чадварыг олгож бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгссөн сурагчдад ЭЕШ-ийн оноо, бэлтгэл хөтөлбөрийн сурлагын амжилтын дүнгээр тэтгэлгийн төрлийг хуваарилах юм байна. | 100% | |
| 19. | Засгийн газарт чиглэл өгөх | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод | Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан "Нэг өрх-нэг мод" аяныг 2021.05.17-ны өдөр зохион байгуулж иргэн, аж ахуйн байгууллагуудад 12 нэр төрлийн 1046 | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | ширхэг мод үнэгүй олгов.<br>Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд 26 аж ахуйн нэгж байгууллагын 135 албан хаагч, 577 иргэн 1815 ширхэг мод тарив. | | |
| 20. | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | Дүүргийн 1-р хорооны хойно байрлах ногооны талбайн хүдгаас 7,1 га-д тариалсан мод, бутны арчилгаа болон цэнэг усалгааг Багахангай тохижилт ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна. | 100% | |
| 21. | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | Хавар, намрын улирлуудад мод тарих өдөрлөгийг зохион байгуулж дүүргийн цаг агаар, уур амьсгалаас шалтгаалж салхин талдаа улиас, бургас модлог ургамлуудыг тариалж байна. Мод тарихдаа Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын Бобкат механизмаар модны нүх ухах ажлыг хийж гүйцэтгэн мод тарихад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100% | |
| 22. | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | 2022 онд Цагаан хаалганы зүүн урд талд 5,1 га, ногоон паспорт төгөлд 7 га, өндөрлөгийн урд талд 5 га газарт мод тарихаар төлөвлөөд байна. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангаас ногоон байгууламжийн чиглэлээр 60,0 сая төгрөгийг шийдвэрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 100% | |

| |
|---|
| Хэсгийн дундаж:100% |
| Нийт үнэлгээ 98.3хувь |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭРДЭНЭТУЯА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН